



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 08 сарын 10 өдөр

Дугаар МЧ8

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5.“а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12/02 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 3.2.9.65, Сангийн сайдын “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” батлах тухай 2012 оны 239 тушаалын хавсралтын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол сумын Соёлын төв, Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуульд тус бүр 1 ширхэг зөөврийн компьютер, сумын Засаг даргын Тамгын газарт 2 ширхэг зөөврийн компьютер авах зардалд 7.325.000 (долоон сая гурван зуун хорин таван мянга) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100107